



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/130

Мандалговь

Г Шагнаж, урамшуулах тухай 7

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4, аймгийн Засаг даргын 2018 оны А/407 дугаар захирамжаар батлагдсан "Шилдэг төрийн албан хаагч шалгаруулж, урамшуулах журам"-ын 4.3 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 05 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2018 оны аймгийн "Шилдэг төрийн албан хаагч"-аар нэр бүхий 2 эмчийг журмын дагуу шалгаруулж тус бүр өргөмжлөл, 1.000.000 төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

Хоёр. Шилдэг төрийн албан хаагчаар шалгарсан эмч нарын нэрсийг 1 дүгээр, урамшууллын зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. "Малчин телевиз"-ээс санаачлан зохион байгуулсан "Уяачид дуулж байна" улсын анхдугаар уралдаанд амжилттай оролцож, Гран-при хүртсэн Өлзийт сумын уяач Д.Лхагва-Очирт аймгийн "Хүндэт өргөмжлөл" олгож урамшуулсугай.

Дөрөв. Шагналын зардалд шаардагдах 2.147.000 /Хоёр сая нэг зуун дөчин долоон мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГазар /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Г.Мөнхбаясгалан / нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200441



Аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 02-ний өдрийн /15/ тоот захирамжийн 1 дүгээр хавсралт

Шилдэг төрийн албан хаагчаар шалгарсан эмч нарын нэрс

№	Овог нэр	Албан тушаал
1	Нямсүрэн Цэрэндулам	Нэгдсэн эмнэлгийн дотрын эмч
2	Түвшинбаатар Шинэбаяр	Нэгдсэн эмнэлгийн мэс заслын эмч



Аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн /130/ тоот захирамжийн 2 дугаар хавсралт

Шилдэг төрийн албан хаагч нарыг урамшуулах, урамшууллын зардал

№	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Урамшуулал	2	1000000	2.000.000
2	Өргөмжлөл	2	50000	100.000
3	Хүндэт өргөмжлөл	1	35000	35000
4	Батламж	2	6000	12000
	ДҮН			2.147.000